



ХҮҮХДИЙН СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ



*МУБИС - ийн СӨБС- ийн захирал, доктор (Ph.D),
профессор Ж.Батдэлгэр*

Хүүхдийн хөгжилд үр хөврөлийн болон үргийн өсөлт хөгжил чухал нөлөөтэй болох нь

Төрөхөөс гурав хүртэлх насны хөгжил нь хамгийн эрчимтэй, мэдрэмтгий үе

Сургуульд орох хүртэлх насны хүүхдийн сэтгэцийн хөгжлийн зарим онцлог

Дүгнэлт


Түлхүүр үгс: хүүхэд нас, хөгжил, үргийн хөгжил, эрчимтэй болон мэдрэмтгий үе, эмзэг үе, хөгжилд гарах сэтгэцийн шинэ бүрдэл.

Бид эл өгүүлэлдээ хүний сэтгэцийн амьдралд хүүхэд төрөхийн өмнөх болон хүүхэд насны хөгжил ямар нөлөөтэй болох, хүүхдийн сэтгэцийн хөгжлийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг өгүүлэхийг зорилго. Монголчууд “Хий нас” хэмээн нэрлэдэг эхийн хэвлийд хөгжиж байгаа үргийн өсөлт хэрхэн эрчимтэй явагддаг нөгөө талаас, ураг гадны зохисгүй нөлөөлөлд амархан өртдөг эмзэгэн болохыг, хэрэв энэ үед ураг гаднах ба дотоод орчны хортой зохисгүй нөлөөнд өртсөнөөс бие эрхтний бүтцэд гажиг согог үүсэх улмаар оюун ухааны төрөлхийн хомсдолд ч хүргэж болзошгүйг бичсэн. Түүнчлэн төрсний дараах амьдралын эхний таван жилд хүүхдэд танин мэдэхүйн болон бие хүний хувийн шинж бүрэлдэж эхэлдэг, эл насанд хүмүүжүүлэх уламжлалт арга зарчмын талаар өгүүлэх болно.

Нэг. Монголчууд хүний насыг тоолохдоо “хий нас” гэж бүтэн нэг насыг тооцдог нь их учиртай. “Хөл хүндтэй эхийн өмнүүр хөндлөн гардаггүйн учрыг таньяа даа” гэж дуулаад байдаг нь эхийн хэвлий дэх

хүүхэд чухамдаа “Гэгээрсэн бурхан” байгаа гэдгийг хэлсэн гүн гүнзгий агуулга бүхий учирлал буюу. Орчин үед лозитрон, томограф, эхо, соронзон хэлбэлзлийн бичлэг зэрэг шинэ технологийн ачаар эхийн хэвлий дэх үргийн амьдрал, төрсний дараах нялх хүүхдийн уураг тархины хөгжлийг ажиглаж судлах нь шинжлэх ухааны шинэхан салбар болоод байна. Үр хөврөлийн болон үргийн өсөлт ямар эрчимтэй явагдахын зэрэгцээ эмзэг мэдрэмтгий болохыг 1-р зурагт үзүүлэв. (1-р зураг) –ийг үзнэ үү.

Эхийн умайн дахь үргийн өсөлт 3 үетэй байхаас эхний 8 долоо хоногт хөгжлийн хамгийн эмзэг мэдрэмтгий үе болохыг та зурагт үзүүлсэн муруйгаас харж байна. Мэдрэлийн сувганцараас уураг тархи, нугас үүсч, зүрх цохилж, мэдрэхүйн эрхтнүүд (нүд, чих, ам) бөөр, элэг, цусны эргэлт бий болдог. Энэ үед үргийг аливаа гадны зохисгүй нөлөөллөөс хамгаална. Учир нь энэ хугацаанд эрхтэн үүсч хөгждөг учраас **бие эрхтний бүтцийн хөгжлийн хэвийн бус байдалд орж болзошгүй үе гэдэг.** Харин найм дахь долоо хоногоос гуч дахь долоо хоног хүртэлх хугацаанд дотоод эрхтнүүд байр байрандаа, гэдэс хүчил ялгаруулж, элэг улаан бөөмсийг үйлдвэрлэдэг, сүүн шүдний бүрдэл эхэлдэг, ураг тийрдэг, шүлсээ залгадаг, хуруугаа хөхдөг, үс нь ургаж, сормуус хөмсөг тодордог бөгөөд хүйсийг тодорхойлох боломжтой болно. Өөрөөр хэлбэл, булчингийн хөгжил сайжирч эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа бүрэлдэн явагддаг учраас энэ үед хортой зохисгүй нөлөөнд (архи, тамхи, мансууруулах бодис, өвчин, тэжээлийн болон агаарын дутагдал г.м) ураг өртөгдвөл **сэтгэцийн гажиг, оюун ухааны хомсдол үүсч болзошгүй үе байдаг.**



Зураг 1. *Эх сурвалж: Child psychology a contemporary viewpoint, third edition, Norman Garnezy, 2002, 65 page.*


Орчин үед ураг мэдрэх эрхтнүүдээ бидний таамаглаж байгаагаас хамаагүй өмнө ажиллуулж эхэлдгийг эхогийн түслэмжтайгаар ажиглаж бүрэн нотоллоо.

Баримт1. Дууны өнгө болон хэмнэл нь бараг өөрчлөгдөхгүйгээр урагт хүрдэг болохыг баталжээ. Эхийн хэвлийд байхдаа хүүхэд эхийнхээ дуу хоолой, өнгө аясыг сонсдог. Эхийн дуу хоолой бусад дуу чимээнээс илүү хүчтэй сонсогдоно. Хүүхдийн анхны сэтгэлийн хөдөлгөөний холбоо, харилцааг энэхүү дуу чимээ бий болгодог. Иймд төрөөд эхийнхээ дууг хамгийн түрүүнд бусад хүнийхээс ялгадаг, тэр дуу чимээгээ сонсоод маш тайван болдог. (2. 39)

Баримт 2. Сонсож буй дуу нь таалагдаж байвал тайвшран, таалагдахгүй байвал уурладаг. Хурц гэрэл, чимээ шуугиан, даралт эсвэл өвдөлтөд биеэ огцом хөдөлгөж эсэргүүцдэг. Зөөлөн ба хүчтэй тийрэлтээр тавгүйтэж байгаагаа илэрхийлдэг. Эхогоор ажиглахад, ихэр ургууд тийрэлцэх, нэг нэгнийхээ гарыг атгах, тойрох үйлдлийг байнга давтаж байжээ. Эндээс хүүхэд бүр хэл хөгжихөөс өмнө биеийн хэлээрээ мэдээлэл авч өгөлдөг болох нь харагдаж байна. (С. Евилмаз 5. 25)

Хоёр. Хүний уураг тархины хөгжлийн үйл явцын хамгийн чухал үе нь эхний гурван жилд явагддаг. Ургийн тархинд ойролцоогоор 100 тэрбум эд эс байдаг. Энэ нь амьдралын туршид хангалттай хүрэлцэх тоо юм. Эд эсүүд бодож, санахын гол хэсэг болох тархины хальсанд яг зөв байрлалаа олсон байх ёстой. Хэрэв замаа олохгүй бол (архи, тамхи, мансууруулах бодис, урт хцгацаанд эм уух г.м.) хөгжлийн ноцтой саатал үүсч болзошгүйг бид өгүүллийн эхэнд бичсэн. Судалгаанаас харахад, гурван нас хүрэхэд уураг тархи нь дүгнэлт гаргадаг. Сэрээгдээгүй эд эс үхдэг. Тархины эд эс өөрийгөө шинэчилж чаддаггүй. Иймээс гурван насны эцэст уураг тархины хэмжээ 90 хувьд хүрч боловсорсон байдаг. Үлдсэн 10 хувь нь 10 нас хүрээд, арван зургаан насанд хүрсэн хүний тархины хэмжээ нь түүний насан туршдаа ашиглах хэмжээ нь юм. (5. 31).

Хүний мэдрэхүй болон сэтгэц зан үйлийн дээд чиг үүргүүдийг зохицуулах үүрэгтэй нэг талаас, нөгөөтэйгүүр хүний сэтгэцийн амьдралын материаллаг үндэс - хэл яриа хөгжих үйл явцыг та 2-р зургаас хараарай.



Зураг 2. Эх сурвалж : C. Nelson, in from **Neurons to Neighborhoods, 2000**

Хүний сэтгэцийн үйл явцын чухал сэрэхүйн үзэгдэл - харах чадвар, сонсохуйн мэдрэхүйн тогтолцоо, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, хариу үйлдэл үзүүлэх, нийгэмших илрэл, хэл яриа, үсэг тэмдэглэгээ болон тоо, хэлбэр, хэмжээний анхны төсөөлөл бий болох мэдрэмтгий үе хэдэн наснаас эхэлж хэдэн насанд алгуур буурах хандлагатайг 3-р зургаас үзнэ үү.



Зураг 3. Эх сурвалж: **The Canadian Institute for Advanced Research 2002**

Судлаач, доктор Г.Оросоо амьдралын эхний гурван сард хүүхдийн хөдөлгөөн, хэл яриа, сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд чанарын өөрчлөлт гардгийг судалжээ. Тэрээр эх хүүхэдтэйгээ ярьж, эелдгээр өхөөрдөж дуудахад хүүхэд **мишээж, гар хөлөө савчин хөдөлгөж, ганганаж гунганан** хариу үйлдэл хийж байжээ. (1.34) Хүүхэд ийм хариу үйлдэл үзүүлэх нь цаашид хэлд орохын урьдал нөхцөл, үндсэн хөдөлгөөн эзэмших бололцоотойг харуулахын хамтад цаашдын хөгжлийн **“шимтэй хөрс”** бий болсныг харуулж байгаа хэрэг. Эндээс хүүхдийн нэг ойтөйд илрэх сэтгэцийн шинэ бүрдэл бол хөдөлгөөн, хэл яриа, сэтгэлийн хөдөлгөөн, харилцааны хөгжилд гарах ахиц дэвшил юм. Сэтгэл судлаачид эл цогц хариу илрэлийг

нялх наснаас балчир нас 1-3 эхлэх зааг дээр үүсдэг гэдэг ч 1,5 - 2 сард тод ажиглагддаг байна. Хэрэв балчир насанд энэ шинж ажиглагдахгүй бол сэтгэцийн хөгжлийн хоцрогдол, саатал байна гэж үздэг. (7,186)

Эмч хүн хүүхдийн зүрхийг чагнуураар чагнаж, эсвэл нүүр царайг нь ажиглан шинжиж өвчнийг тодорхойлдогтой адил сэтгэлзүйчид дээрх цогц шинж илэрч байгаа эсэхээр сэтгэцийн эрүүл мэндийг оношилдог.

3 хүртэлх нас хүүхдийн өсөлт хөгжлийн гайхамшигтай үе. Энэ насанд хэзээ ч дахин давтагдахгүй хүртэхүйн хөгжлийн алтан үе заяажээ. (КЛ Печора, 1981) Энэ үед хүүхэд эд юмсыг барьж атгах, базлах, шидэх, амандаа хийх зэрэг үйлийг хийдэг. Манай ард түмэн ямар сайндаа **“Далан чавганцын нас”** гэхэв. Өөрөөр хэлбэл, хүүхэд эд юмстай харьцах замаар юмсын шинж чанар, хэмжээ, хэлбэр, өнгийг танин мэдэж эхэлдэг. Хөлд, хэлд орж байгаа нь хүүхдийн төрөлхийн сониуч занг улам сэдэлжүүлнэ. Хүүхэд өөрийн **“Би”**-г ойлгоно. **“Би чадна, Би хийнэ”** гэж хэлэх нь олонтоо. Өөрөөр хэлбэл, би тусгаар хүн гэдгээ мэдрэж бие хүний хувийн шинж бүрэлдэнэ. Айж ичих мэдрэмж бий болно. Ийнхүү 3 хүртэлх насанд танин мэдэхүйн болон бие хүний хөгжилд чанарын өөрчлөлт гардаг.

Яагаад энэ насыг эгзэгтэй үе гэж үздэг вэ? мэдрэхүй, ой тогтоохуй, хэл яриа болон хувь хүний шинж бүрэлдэж эхэлдэг энэ үед нь хөгжлийг нь дэмжихгүй, хайхарч анхаарахгүй бол цаашдын хөгжилд сөрөг үр дагаврыг магадгүй хөгжлийн хоцрогдлыг дагуулна. Иймд хөгжих ёстой энэ үеийг насанд хүрэгчид хэзээ ч алдаж болохгүй. Үүнийг шинжлэх ухааны олон баримтаас харж болно.

Баримт 1. Энэтхэгийн сэтгэлзүйч Рид Сингх хүүхэд насаа чононууд дунд өнгөрөөсөн хоёр охиныг олж, хүний орчинд авчирсан боловч тэд дөрвөн хөллөн мөлхөж, шөнөдөө чоно шиг улир амьтны олон шинжээс салж чадахгүй байжээ.

Баримт 2 «10-12 насны цагаан арьст хүүхдийг африкийн ойгоос сармагчид дундаас олсон байна. Тэр сармагчны зан авирыг бүрэн төгс эзэмшсэн байв. Түүнийг ярьж сургах гэж хичнээн ч оролдоод үр дүнд хүрээгүй бөгөөд тэр инээж ч чадахгүй байв» хэмээн тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, хэл яриа хөгжих хамгийн мэдрэмтгий тэр үед хүний хэлийг эзэмшиж чадаагүйтэй холбоотой.

Гурав. Сургуулийн өмнөх насанд бие хүний чухал шинж бүрэлдэн бий болдог нас. Энэ насанд юмгы амархан тогтооно, хүүхэд зураг зурна, наана, хайчлах зэргээр бүтээлч дүрслэн бодохуй хөгжинө, хүүхдийн яриа утгатай болж асуулт тавьж бодол санаагаа чөлөөтэй илэрхийлнэ. Тоглох явцад юмсыг орлуулан сэтгэж тоглоно. Хүүхдийн хөгжилд тоглоом чухал байр суурь эзэлдэг. Тоглох явцад хүүхдийн танин мэдэхүй өргөжиж нийгмийн туршлагын



аргыг эзэмшинэ. Тоглох нь хүүхдийн уураг тархинд чухал нөлөөтэй. Тоглоомоор дамжуулж хүүхдийн үгийн нөөц нэмэгдэж, шинэ мэдлэг эзэмшиж, аливаа зүйлийг өөрийнхөөрөө төсөөлж баяр баясгалантай болдог. Энэ наснаас хүүхэд тусад орно. Юм бүхнийг мэдэхийг хүсч сониуч зан, танин мэдэх эрмэлзэл улам нэмэгдэнэ. Балчир насанд **Энэ юу вэ?, Тэр юу вэ? Хаана?** гэж асуудаг бол 4 наснаас эхлэн **Яагаад ингэдэг юм бэ? Ямар учраас?** гэсэн асуултаар солигдоно. Эл насанд илэрч буй сэтгэцийн эдгээр шинжүүд цаашид түүнийг сургуульд амжилттай суралцах, төлөвшлийн үндэс суурь болно.

Эцэст тэмдэглэхэд, хүүхдийн тодорхой насанд сэтгэцийн хөгжилд гарч байгаа шинэ бүрдэл, чанарын өөрчлөлтийг анхаарч яаж хөгжүүлж, хүмүүжүүлэх аргаа сонгодог. Улс үндэстэн болгон өөр өөрсдийн соёл

иргэншлийнхээ дагуу хүүхдээ эхийн хэвлийд байхаасаа эхлэн хэрхэн яаж хүн болгох, хайрлаж, зэмлэж байгаагаа яаж мэдрүүлэх зорилгоор сайн үр хүүхдийн төлөө санаа тавьдаг арга туршлагатай байдаг. Тухайлбал, африкчууд хэвлий дэх урагт зориулан дуулж бүжиглэж, япончууд уламжлалт хөгжмийн зэмсэг болох Тайкиогоо тоглож, хятадууд хоолны дэглэмд анхаарч хөгжим сонсгож, исламчууд эхийн хэвлийг илэн Коран уншиж, монголчууд хэвлий дэх хүүхдийг **“Хий нас”** хэмээн бүтэн нэг нас болгон тооцож тулгар эхийн ёс жаягийг баримталж иржээ. Тэрээр **“Хавиргатай гэдсэндээ багтаан байхад нь анхаарахгүй бол ханат гэртээ багтаахгүй хүн болно”** хэмээн хүүхдийг эхийн хэвлийд байх үеэс анхаарах тухай ухаант ард түмнийхээ оюун дүгнэлтийг шинжлэх ухааны үүднээс судлах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Манай ард түмэн хүүхдээ **“Галын бурхан”** хэмээн анхаарч 0-6 насанд нь хан хөвгүүн мэт асар хэмээсэн нь яах аргагүй хүүхдийн зөв хөгжил, эрүүл саруул байдал нь томчуудаас шууд хамааралтай, энэ насны хүмүүжил төлөвшлийн тавил нь цаашдын хөгжлийн суурь үндэс болохыг анхаарч байсантай холбоотой буюу.

Амьдралын анхны мөчөөс эхлэн хүний орчинд хүн болох бүх төрлийн дэмжлэг туслалцаа, нөлөөлөл явагдах учраас хүүхэд бүр бага наснаасаа эхлэн биологийн бүтээгдэхүүн биш, соёлжин иргэнжиж байгаа бие хүн болж хувирдаг. Энэ үе хэдий наснаас эхлэх талаар судлаачид өөр өөрийн үзэл бодолтой байдаг ч ойролцоогоор 2-3 насны үеэс хүүхдийн танин мэдэхүйн болон бие хүний хөгжлийн эхлэл эрчимтэй болж ирнэ. Мөн энэ үеэс хувь хүний хөгжлийн боломж, авьяас, давуу талууд нэмэгдэхийн хэрээр хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах зам нэг адил нээгдэнэ. Хэрэв сая төрсөн хүүхдүүдийг эхнээс нь сургаж, нийгмийн амьдралд дадлагажуулах, тэдэнтэй ажиллах насанд хүрэгчид байхгүй гэж үзвэл тэр нялх хүүхдүүдийг хооллож ундааж байлаа ч гэсэн тэдний сэтгэцийн хөгжил зохих хэмжээнд явагдахгүй хэдэн арван мянган жилийн өмнөх шиг хөгжлийн доод төвшинд үлдэж болох үндэслэлтэй. Хөгжлийн тодорхой эл чухал үеийг анхаарахгүй, анзаарахгүй байж үл болно. Хүүхдийн төлөө зардал бол ирээдүйн төлөө хийж байгаа хөрөнгө оруулалт мөн. Эндээс хүүхэд бүр бага балчраасаа эхлээд амьдралаа аль болох сайн сайхнаар эхлүүлэх боломж олгох зайлшгүй шаардага бий болж байна.

НОМЗҮЙ

1. Батдэлгэр Ж, Оросоо Ш. Бага насны хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онцлог.Уб., 1999 он
2. Возрастная психология, Хрестоматия, научные редакторы В.С. Мухина, А.А. Хвостов, М, 2003
3. Балхаажав Ц. Хүний хөгжлийн онол аргагүйн философи үндэслэл, Судалгаа, ажиглалт, бясалгал, дүгнэлт, Уб.,1992 он
4. Дэлхийн хүүхдийн байдал - 2001 он, Уб., UNICEF,
5. Ээжээ би таныг сонсож байна., Сэхэр Еылмаз, Empathy төв, 2008 он
6. Child psychology a contemporary viewpoint, third edition, Norman Garnezy, 2002
7. Словарь практического психолога. (Психоанализ и другие направления, методика исследования глубинного сознания) В. Шапарь, Москва, 2006.